

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
4 ДҮГЭЭР САРЫН 01-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-12
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	13-147
	1. Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай	17-19
	2. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	19-25
	3. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл <i>/Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	25-29
	4. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд <i>/Засгийн газар 2021.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	29-44
	5. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Засгийн газар 2021.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	44-82
	6. Цаг үеийн шинжтэй асуудлаар мэдээлэл сонсох: Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 45 дугаар захирамжаар байгуулагдсан “Оюу Толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, Оюу Толгой төслийн гаднын хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгээс хэрэгжүүлж буй ажлын явцын талаар	82-147

Хураангуй тэмдэглэл

Хоёр.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн бөгөөд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Хунан, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Золжаргал, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Б.Галсанбат нар байлцав.

Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг “Их хуралдай” танхимаас танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “арга” гэсний дараа “хэрэглэж” гэж нэмж, мөн зүйлийн 7.1.2 дахь заалтын “алдар хүнд, нэр төрийг” гэснийг “үйл ажиллагааг” гэж өөрчилж, 7.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.3.хүний эрх, эрх чөлөө, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, С.Одонтуяа, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	35
Татгалзсан:	28
Бүгд:	63

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Энэ хуулийг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	40
Татгалзсан:	23
Бүгд:	63

63.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Хүний эрх хамгаалагч нь хүчирхийллийн арга хэрэглэж, тайван бус аргаар үйл ажиллагаа явуулсан, явуулахыг уриалсан, хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хувийн ашиг сонирхолд ашигласан, хүний эрх, эрх чөлөөг зөрчиж, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	40
Татгалзсан:	23
Бүгд:	63

63.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамтад өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн бөгөөд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Хунан, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Золжаргал, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Б.Галсанбат нар байлцав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

***Хоёр.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн
мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хүний эрх, хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын эрхэм гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Ц.Мөнхцэцэг гишүүнийг индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатараас 2020 оны 5 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүний эрх, хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийг баримтлан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу зарчмын зөрүүтэй хоёр санал, Хүний эрх хамгаалагч эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар хуулийн төсөл хоорондын зөрчлийг арилгах шаардлага гарсан тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу нэг зарчмын зөрүүтэй санал боловсруулан Байнгын хорооны хуралдаанаар санал хураалгасан бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг хуулийн төсөл батлагдсанаар орон тоо хэрхэн нэмэгдэх, Хүний эрхийн үндэсний комиссын гишүүдийн тоог нэмэх шаардлагагүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Монгол Улсад хүний эрхийн зөрчил гарсаар байгаа тул хүний эрх, хамгаалах тооцоог боловсронгуй болгох нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд одоогийн орон тоогоор ажиллах бүрэн боломжтой гэж үзэж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар хүний эрхийн хамгаалагчийн үйл ажиллагааг улс төрийн зорилгоор ашиглах эрсдэл үүсгэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт хүний эрхийн хамгаалагч нэрээр бусдын нэр төр, алдар хүндийг гутаах явдал гарахгүй байх талаар асуулт асууж, санал хэлсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүний эрх, хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй гурван санал байна.

Хүний эрх, хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал байна. Хууль зүйн байнгын хороо гаргасан.

1.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “арга” гэсний дараа “хэрэглэж” гэж нэмж, мөн зүйлийн 7.1.2 дахь заалтын “алдар хүнд, нэр төрийг” гэснийг “үйл ажиллагааг” гэж өөрчилж, 7.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.3.хүний эрх, эрх чөлөө, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо.

Дамдины Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс оруулж ирж байгаа саналуудтай зарчмын хувьд хуулийн төслийг боловсруулсан хүний хувьд, мөн түүнчлэн төрийн бус байгууллагуудтайгаа бид зөвлөлдөөд ярьж байгаа. Зөв санал орж ирж байгаа юм.

Зүгээр нэг зүйлийг анхаармаар байна. Одоо энэ бусдын нэр хүндэд халдахгүй байх энэ заалтууд чинь бусад хуулиараа зохицуулагдсан. Монгол Улсад бүх хүнд хориотой. Тэр дотроо тэгэх тусмаа хүний эрхийг хамгаалах хүмүүст бол бүр хориотой зүйл л дээ.

Тэгэхлээр нэгэнт бусад хуулиар хоригдчихсон зүйлийг энд онцгойлон оруулж ирснээр дараа нь хууль хэрэглэх үед харин хүний эрхийг хамгаалж байгаа хүмүүсийгээ улам хязгаарлах гэсэн тийм байдлаар хэрэглэж явах уу гэдэг ийм эрсдэл үүсэж байгаа шүү. Үүнийг тал талдаа анхаарч ажиллах ёстой шүү. Нэг.

Хүний эрхийг хамгаалагчийн хууль оруулж ирлээ гээд бүр харин эрхийг нь хаах гэсэн тийм байдлаар уншигдаж дараа нь тайлбарлагдаад байх вий гэж болгоомжилж үүнийг хэлж байгаа юм.

Тэгэхлээр хуулийг дараа нь хэрэглэх үедээ энэ хууль санаачлагчийн хэлж байсныг протоколд оруулмаар байна. Үүнийг анхаарч. Хэрэглэхдээ үүнийг бодолцож ажиллах ёстой шүү.

Г.Занданшатар: Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Тэгэхээр 7.2.1 дээр санал байгаа юм. Би уг нь ажлын хэсгийн гишүүн.

Тэгээд надтай бас энэ Хүний эрхийн форумын маш олон гишүүн байгууллагууд уулзсан. Энэ дээр сая Д.Цогтбаатар даргын хэлж байгаагаар

өөр хуульд тусгагдчихсан заалтыг давхар тусгах шаардлагагүй юм гэдэг дээр зарчмын санал байгаа юм.

Тэгээд би бас ажлын хэсгийнхэнтэйгээ яриад энэ дээр дэмжигдсэнгүй. Үүнийг эцсийн хэлэлцүүлэг дээр ярьж хэлэлцэх хэрэгтэй байна. Эсвэл протокол тэмдэглүүлэх хэрэгтэй байна.

Энэ ямар заалт юм бэ гэхээр 7.2.1 дээр гадаад улсын тусгай албад, түүний халхавч байгууллага үндэсний эв нэгдлийг бусниулах гээд. Ийм байгууллагуудаас санхүүжилт авахыг хориглоно гээд. Гэтэл үүнийг оруулах шалтгаан байхгүй. Яагаад гэхээр энэ хууль өөрөө Мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, Эрүүгийн хууль, бусад бүх хууль тогтоомжуудад нарийвчлаад тусгачихсан байхад үүнийг заавал төрийн бус байгууллагууд дээр ингэж хориг тээг тавих нь буруу юм гэдгийг форумын гишүүн байгууллагууд ажлын хэсэгт ирүүлсэн байгаа.

Тэгээд энэ асуудлыг бас онцгойлон анхаарах хэрэгтэй. Нэгдүгээрт өөр хуульд орсон. Хоёрт, үүнийг төрийн бус байгууллагууд дээр үүрүүлэх шаардлага байхгүй гэсэн ийм санал байгаа юм. Тэгээд энэ дээр нэлээд нарийвчлаад бүх зүйл, заалтаар бичээд өгчихсөн. Өөрөөр хэлбэл бусад олон хуулийн заалттай давхардуулчихсан байгаа.

Тэгэхээр үүнийг бид бусад хуулийн зүйл, заалтыг давхардуулан заахгүй гэсэн энэ хуулийг зөрчөөд байгаа юм. 7.2.1. Тэгэхээр энэ дээр Д.Цогтбаатар дарга хариулт өгөх үү? Ц.Мөнхцэцэг дарга хариулт өгөх үү? Энэ их олон байгууллагуудтай уулзаж бас энэ санал гарсан юм л даа.

Г.Занданшатар: Энэ асуулт, хариулт гэж байхгүй. Энэ зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор дэмжсэн, дэмжээгүй үг л хэлнэ. Сая та үг хэлчихсэн. Одоо болоо.

Одоо Баттөмөрийн Энхбаяр гишүүн цахимаар үг хэлнэ. 1 минут гэж байхгүй.

Б.Энхбаяр: Баярлалаа. Хүний эрхийн хамгаалагчийн хуулийн төслийг дэмжиж байгаа. Энэ бол хүн болгоныг хүний эрхийг хамгаалагч болгож байгаа чухал хууль.

Тэгэхээр өчигдөр Засгийн газраас С.Зоригийн хэргийг улсын нууцаас гаргалаа гэдэг мэдээллийг цацсан. Тэгээд гурван сая иргэн тэр ганц хэргийг бүгдээрээ танилцаад үзээд байх боломж байхгүй. Өмнө нь хоёр удаа Засгийн газраас нууцаас гаргаж байсан гээд. Бас л танилцуулж байгаагүй.

Тийм учраас үүнтэй холбоотой асуудал дээр энэ дээр ер нь Улсын Их Хурал манлайлал үзүүлж. Бүр Улсын Их хурлаар болдоггүй юм бол Хууль зүйн байнгын хороо нээлттэй байдлаар ил болгосон С.Зоригийн амь насаа алдсантай холбоотой хэргийн үйл явцыг хэвлэл мэдээллээр шууд нээлттэй байдлаар дамжуулж танилцах асуудлыг шийдмээр байна. Өөрөөр хэлбэл хүний эрх хамгаалах асуудлаа Улсын Их Хурал хууль хэлэлцэж баталж байгаатайгаа зэрэгцэн яг одоо энэ болж байгаа үйл явдалтай холбоотойгоор

бас энэ дээр шуурхай санаачилгатай ажиллавал яасан юм бэ гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэллээ. Бүртгэлийн санал хураалт эхлээд явуулъя.

Энэ хооронд нэг зүйл анхааруулахад. Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1.2-т Монгол Улсын иргэний үндсэн үүрэгт бусдын хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх гэж байгаа.

Тэгэхээр тэр утгаар нь илүү ойлгоод явчихвал энэ заалтыг хэрэгжүүлэхэд нь бас илүү тус дөхөм болох болов уу. Бас манай төрийн бус байгууллагуудаас тавьж байгаа саналуудаа ч гэсэн энэ Үндсэн хуулийн зарчим, хүний үндсэн үүрэгт хамаарч байгаа учраас. Энэ жагсаал, цуглаан ч бай. Бусад бүх үүрэгт хамаарна. Бусад заалт ч гэсэн бас энэ хүний эрх бол дэлхий даяар ганцхан зүйлээр хязгаарлагддаг. Үндэсний аюулгүй байдал гэсэн. Үүний ч бас тэнцвэрийг олохгүй бол юмыг бас нэг тал руу хэт туйлшруулах тусам хууль хэрэгжилтэд саад учирдаг.

Ийм учраас үүнийг хууль хэрэгжүүлэхдээ анхаарч ажиллах ёстойг протоколд тэмдэглэж үлдээлгэж байна. Ингээд санал хураалт явуулна.

Ингээд бүртгэлийн санал хураалт явуулъя. Туршилтын.

30 гишүүн бүртгэлд ороогүй. 33 гишүүн бүртгэлд орлоо.

Одоо санал хураалт явуулна. Энэ заалтыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

63 гишүүн оролцож, 35 гишүүн дэмжиж, 55.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Энэ хуулийг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 40 гишүүн дэмжиж, 63.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана.

Энэ бол Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Хүний эрх хамгаалагч нь хүчирхийллийн арга хэрэглэж, тайван бус аргаар үйл ажиллагаа явуулсан, явуулахыг уриалсан, хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хувийн ашиг сонирхолд ашигласан, хүний эрх, эрх чөлөөг зөрчиж, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 40 гишүүн дэмжиж, 63.5 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Ингээд Хүний эрх, хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамтад өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

Энэ Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль эцсийн хэлэлцүүлэгт шилжиж байна. Тэгээд энэ хуулийн төслийг санаачилсан манай Д.Цогтбаатар гишүүн, ажлын хэсгээр ажилласан Ц.Мөнхцэцэг гишүүд сайн ажиллалаа. Одоо эцэслэн батлах бэлтгэлийг сайтар хангах ёстой.

Энэ хуулийг баталснаар Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан Монгол хүний эдлэх үндсэн 18 эрхийг хангах, улмаар шударга ёсыг тогтоох үйл хэрэг алхмаар урагшилж байна.

Монголын ард түмний хүсэмжлэл бол **“шударга ёс”**. Шударга ёсыг тогтоох үндэс суурь нь **“шударга шүүх”**, **“шударга төр”** юм байгаа юм. Монгол Улсад монгол хүний эрхийг баталгаатай хангаж байж шударга ёс тогтоно.

Хүний эрхийн хамгаалагчийн хуулийг баталж байгаа нь өчигдөр би энэ Хүний эрхийн комиссынхон, энэ цар тахлын үеийн хүний эрхийн нөхцөл байдал, 2020 оны хүний эрхийн илтгэлээ Улсын Их Хуралд өргөн барьсан. Ойрын үед хэлэлцэнэ.

Нэг талаасаа энэ бол зөвхөн Хүний эрхийн Үндэсний Комиссын ажил биш. Тэгэхдээ Хүний эрхийн Үндэсний Комисс зоригтой ажиллаж хүний эрхийг хамгаалдаг институц байх шаардлагатай байгаа шүү. Одоо энэ “хүний эрх хамгаалагч” нар л тэмцдэг. Хүний эрхийн комисс дуугүй байгаад байж таарахгүй шүү.

Хүний эрх ер нь алхам тутам зөрчигдөж байгаа. Хууль болгонд суугаагүй. Дандаа төрийн эрхийг дээдэлж байгаа. Нэг талын эрхийг дээдэлж байгаа. Энэ асуудлыг л өөрчлөх гэж энэ хууль батлагдаж байгаа. Том хамгаалалт, дэмжлэг та бүхэнд өгч байгаа гэдгийг ойлгож, идэвхтэй ажиллахыг хүсэж байна.

Товчоор хэлбэл шударга төрийг, шударга ёсыг тогтоох эрхэм зорилго маань алхам алхмаар амжилттай урагшилж байна. Үүнийг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлын гишүүн бүр, Хүний эрхийн Үндэсний Комисс идэвх чармайлттай ажиллаж байж энэ эрх зүйн хувьсгал, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт амилна шүү гэдгийг онцлон хэлье.

Дараагийн асуудалд оръё.